



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН  
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

# ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ШААРДЛАГА БА ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР

ХЯЛБАРШУУЛСАН  
ХУВИЛБАР

2026





## ГАРЧИГ

1. Хариуцлагатай уул уурхайн шаардлага	2
2. Үндэслэл	3
3. Нэр томъёо ба тодорхойлолт	4
4. Хамрах хүрээ ба шаардлагын бүрэлдэхүүн	5
5. Хариуцлагатай уул уурхайн зарчмууд	6
6. Шаардлага	7,8

## ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР

• Оршил	9
• Хамрах хүрээ	10
• Норматив эш таталт	10
• Хариуцлагатай уул уурхайн зарчим	11
• Шаардлага	12-18



# ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ШААРДЛАГА

Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци (МУУҮА)-ийн Зөвлөл 2006 оны 8 дугаар сарын хурлаараа Монгол Улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилгыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Улмаар Азийн сангийн дэмжлэгтэйгээр төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, бизнесийн байгууллагууд болон судлаачдыг хамарсан оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулж, хариуцлагатай уул уурхайн үзэл санаа, эрхэм зорилго, тодорхойлолт үйл ажиллагааны зарчмыг

боловсруулах ажлын хэсгийг байгуулж ажилласан юм.

Тухайн оны 12 дугаар сард хуралдсан МУУҮА-ийн бүх гишүүдийн хурлаар Ассоциацийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, "Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн зорилго нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарт хариуцлагатай уул уурхайг хөхүүлэн дэмжиж, хөгжүүлэх үйл хэрэгт идэвхтэй оролцох" хэмээн тодорхойлсон.

## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН КОДЕКСИЙН ТҮҮХЭН ТОВЧООН

Уул уурхайн компаниуд үйл ажиллагаандаа дагаж мөрдөх Хариуцлагатай уул уурхайн 8 зарчмыг тодорхойлон батлав. Хариуцлагатай уул уурхайн 8 зарчмыг хэрэгжүүлэх Тунхаг бичигт 80 гаруй байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл нэгдэн гарын үсэг зурав.

"Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс-т" олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг нэгтгэх зорилготой "Хариуцлагаар нэгд" аянд салбарын тэргүүлэх 8 компани нэгдэж Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав

Канадын Уул Уурхайн ассоциатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан тус ассоциацийн "Тогтвортой Уул Уурхайн төлөө" буюу "TSM" (Towards Sustainable Mining) стандартыг нэвтрүүлэхээр тохиров.

2007

2019

2023

2017

2018

2022

НҮБХХ, ИБУИНВУ-ын ЭСЯ-ны дэмжлэгтэй "Хариуцлагатай уул уурхайн санаачилга" ТББ "Хариуцлагатай уул уурхайн гарын авлага" боловсруулав.

НҮБХХ-ийн "Байгаль орчны нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал төсөл"-ийн хүрээнд "Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлгээний аргачлал" боловсруулав.

Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн тусламжтай Хариуцлагатай уул уурхайн кодексийг хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэх заавар боловсруулав.



## ҮНДЭСЛЭЛ

Энэхүү Хариуцлагатай уул уурхайн шаардлагын үзэл баримтлал нь 2007 онд оролцогч талуудын тодорхойлсон "Монголын хариуцлагатай уул уурхай нь эрдэс баялгийн салбарын үйл ажиллагааг тодорхойлогч стандарт мөн" хэмээх үзэл санаа болон "Монголын нийт ард түмэн хариуцлагатай уул уурхайн үзэл санааны дор энэ салбарын талаарх үнэн бодит мэдлэг, мэдээлэлтэй болох, улмаар харилцан санал бодлоо солилцох орон зайг бий болгох явдал юм" гэсэн хариуцлагатай уул уурхайн эрхэм зорилго, түүнчлэн үйл ажиллагааны найман зарчимд тулгуурласан болно.

Мөн Канадын Уул уурхайн ассоциацийн "Тогтвортой уул уурхайн төлөө" буюу

"Towards Sustainable Mining" (TSM) хөтөлбөрийн хэрэгжилтийн загвар, олон улсын сайн туршлагыг харгалзан үзэв.

Хариуцлагатай уул уурхайн шаардлагыг (ХУУШ) нэвтрүүлж хэрэгжүүлэх нь тухайн байгууллагын ерөнхий гүйцэтгэлийг сайжруулах, тогтвортой хөгжлийн санаачилгын суурийг бүрдүүлэх, нийгмийн хариуцлагыг бодитой хэрэгжүүлэх нөхцөлийг хангах ач холбогдолтой бөгөөд байгууллагын стратегийн түвшний шийдвэрт хамаарна. Энэхүү шаардлагад менежментийн тогтолцооны **Төлөвлө-Гүйцэтгэ-Шалга-Сайжруул (ТГШС)** мөчлөг болон эрсдэлд суурилсан сэтгэлгээг хослуулсан үйл явцын арга барилыг хэрэглэсэн.

Энэхүү шаардлагыг нэвтрүүлснээр байгууллагад дараах боломж, давуу тал бүрдэнэ. **Үүнд:**



Иргэд,  
олон нийтийн  
итгэлийг олох  
ба хадгалах;



Байгууллагын  
нэр хүнд,  
үнэлэмжийг  
дээшлүүлэх;



Хууль  
тогтоомжийн  
шаардлагад  
нийцүүлэн үйл  
ажиллагаагаа  
явуулах;



Байгууллагын  
стратегийн  
зорилттой  
уялдуулан  
эрсдэл,  
боломжийг  
тодорхойлж,  
системтэйгээр  
удирдах;

# НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ



Өгүүлбэр эсвэл илэрхийлэл нь "...на, ...нэ, ...но, ...нө" гэж төгссөн бол заавал биелүүлэх шаардлагыг; "...зохино" гэж төгссөн бол зөвлөмжийг тус тус илэрхийлнэ.

## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГЭЖ

бүх холбогдох талууд, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурласан, хууль сахих ёсыг дээдэлсэн, Монгол Улсад байнгын ашиг орлого оруулж байх эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг ойлгоно.

**Тайлбар:** "Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэх тунхаг"-т

## ҮЙЛЯВЦГЭЖ

төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд оролтуудыг ашигладаг харилцан хамаарал эсвэл харилцан үйлчлэл бүхий үйл ажиллагаануудын багц

**Тайлбар:** MNS ISO 9000:2016 Үндсэн ухагдахуун ба нэр томьёо тодорхойлолт

## ШААРДЛАГАГЭЖ

тогтоосон, нийтээр зөвшөөрсөн эсвэл заавал биелүүлэх хэрэгцээ ба хүлээлт

**Тайлбар:** MNS ISO 14001:2016

## АЮУЛГЭЖ

гэмтэл ба/эсвэл эрүүл мэндийн хохиролд хүргэж болох эх үүсвэр

**Тайлбар:** MNS ISO 45001:2018

## ХАБЭМ-ИЙН ЭРСДЭЛ

хүний бие махбод, мэдрэл сэтгэхүй, оюун ухаанд үзүүлэх сөрөг нөлөө

## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНГЭЖ

байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа, агаар, ус, газар, байгалийн баялаг, ургамал, амьтан, хүн ба тэдгээрийн харилцан уялдааг багтаасан хүрээлэх орчин

## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ТАЛБАРГЭЖ

орчинтой харилцан үйлчилдэг, байгууллагын үйл ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний элемент

## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛГЭЖ

байгууллагын хүрээлэн буй орчны талбараас орчинд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн үзүүлэх эерэг буюу сөрөг өөрчлөлт

**Тайлбар:** MNS ISO 14001:2016

## ХАРИУЦЛАГАТАЙ ХУДАЛДАН АВАЛТ ГЭЖ

уул уурхайн байгууллага бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа хууль эрх зүйн шаардлага, хүрээлэн буй орчны менежмент, хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал, хүний эрх, ёс зүй, ил тод байдлын зарчмыг баримталж, тогтвортой хөгжлийг дэмжсэн ханган нийлүүлэгчийг сонгон, хамтран ажиллах үйл ажиллагааг хэлнэ.


## НУТГИЙН ИРГЭДГЭЖ

эрдэс баялгийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон байгууллагын аливаа шийдвэр нөлөөлж болох орон нутагт амьдардаг хувь хүн болон нэгдмэл сонирхолтой бүлэг хүмүүс



## ХАМРАХ ХҮРЭЭ БА ШААРДЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮН

Энэхүү хялбаршуулсан хувилбар нь жижиг, дунд хэмжээний уул уурхайн компаниудад зориулагдсан. Хариуцлагатай уул уурхайн шаардлага (ХУУШ) нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна. Үүнд:



# ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЗАРЧМУУД

Энэхүү шаардлага нь 2007 онд оролцогч талуудын тодорхойлсон хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааны дараах зарчмууд дээр суурилсан болно. Үүнд:



Олон талын  
оролцоог хангах



Хуулийг сахин  
дээдлэх



Дэвшилтэт  
технологид  
суурилсан байх



Ил тод,  
нээлттэй байх



Хүмүүнлэг ёс  
зүйтэй байх



Ирээдүйн хөгжилд  
хөрөнгө оруулах



Хүрээлэн буй орчин,  
хүний аюулгүй байдлын  
өмнө хариуцлага  
хүлээх



Үр өгөөжтэй  
байх





## ШААРДЛАГА

### 6.1



#### КОМПАНИЙН САЙН ЗАСАГЛАЛ БА ИЛ ТОД БАЙДАЛ

6.1.1. Санал гомдол авах, түүнийг шийдвэрлэж, эргэн мэдээлдэг үйл явцтай байна.

6.1.2. Хууль тогтоомжийн шаардлага ба бусад шаардлагыг тодорхойлж нийцлийн үнэлгээ хийсэн байна.

6.1.3. Хариуцлагатай худалдан авалтын бодлого боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх зорилтуудыг тогтооно.

### 6.3



#### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРҮҮЛ МЭНД

6.3.1. Аюул илрүүлэх үйл явцыг бий болгосон байна.

6.3.2. Аюултай холбоотой эрсдэлийг тодорхойлж, эрэмбэлсэн байна.

6.3.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд (ХАБЭМ)-ийн эрсдэл ба боломжуудад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

### 6.2



#### ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА БА ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ

6.2.1. Ажилтны эрхийг хүндэтгэсэн, жендэрийн эрх тэгш байдал болон бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх бодлоготой байна.

### 6.4



#### ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

6.4.1. Хүрээлэн буй орчны талбарыг тодорхойлж, түүнд үзүүлэх нөлөөлөл эрсдэлийг тодорхойлж, эрэмбэлсэн байна.

6.4.2. Эрсдэл ба боломжид чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

### 6.5 НУТГИЙН ИРГЭД БА ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА



6.5.1. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилд ороход нь давуу нөхцөл бүрдүүлнэ.

6.5.2. Орон нутгийн харилцаа хариуцсан ажилтантай байна

## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ШААРДЛАГА (ХУУШ)



### ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР

#### ОРШИЛ

Энэхүү баримт бичгийг Хариуцлагатай уул уурхайн шаардлагын (ХУУШ) хялбаршуулсан хувилбарыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулав.

Энэхүү хэрэгжүүлэх зааварт байгууллагуудын хэрэгжүүлж болох үйл ажиллагааг зарим тохиолдолд жишээгээр тайлбарлав. Эдгээр жишээ нь асуудлыг нарийвчлан тодорхойлох зорилготой бус, зөвхөн боломжит хувилбаруудыг илэрхийлж буй тул бүх байгууллагад шууд хамаарахгүй байж болохыг анхаарах нь зүйтэй.

Бүхий л үйл явц, чиг үүрэгт эрсдэл байдаг. Эрсдэлд суурилсан сэтгэлгээ нь ХУУШ-ын хялбаршуулсан хувилбарыг хэрэгжүүлэх явцад эрсдэлийг тодорхойлох, анхаарах, хянах нөхцөлийг бүрдүүлнэ.

ХУУШ-ын хялбаршуулсан хувилбарыг хэрэгжүүлэхдээ тухайн үйл явцын зорьсон үр дүнг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах арга барилд тулгуурлан дараах үе шаттайгаар хэрэгжүүлж болно.





## ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү хэрэгжүүлэх заавар нь байгууллага Хариуцлагатай уул уурхайн шаардлагын (ХУУШ) хялбаршуулсан хувилбарыг хангах хүрээнд авч хэрэгжүүлж болох боломжит үе шат, арга барилын талаар зааварчилна. Энэхүү заавар нь ХУУШ-ын шаардлагыг нэмж, хасах эсхүл ямар нэгэн байдлаар өөрчлөхгүй. Түүнчлэн хэрэгжилтийн зайлшгүй арга замыг тогтоохгүй бөгөөд тайлбарыг шаардлагаас давуу байдлаар хэрэглэхгүй.

## НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

Хариуцлагатай уул уурхайн шаардлага (ХУУШ), хялбаршуулсан хувилбар 2026

## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

### 1. ХУУЛИЙГ САХИН ДЭЭДЛЭХ:



Уул уурхайн компанийн бүх үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хүрээнд явагдана. Компанийн удирдлага нь хуулиар тогтоосон үүрэг, үйл ажиллагааны хэм хэмжээ, хугацааг чанд мөрдөж ажиллах бөгөөд ажилтнууд болон орон нутгийн иргэдийг хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлнэ.

### 2. ОЛОНТАЛЫН ОРОЛЦООГ ХАНГАХ:



Ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаа болон түүнээс үүсэж болох эерэг, сөрөг нөлөөллийн талаар уурхайн нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэдэд үнэн зөв, бүрэн мэдээлэл хүргэж, ойлголт бий болгоно. Орон нутгийн иргэдийн аж амьдрал, хүрээлэн буй орчинд нөлөөлж болзошгүй шийдвэрийг гаргахдаа тэдэнтэй хамтран хэлэлцэх, оролцоог нь хангах үйл явцыг хэлнэ.

### 3. ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙХ:



Компанийн үйл ажиллагаа болон уурхайтай холбоотой, хуулиар хориглоогүй мэдээллийг сонирхсон этгээдэд нээлттэй, чөлөөтэй, хүртээмжтэй байлгах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна шаардлагатай мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр мэдээллийн самбар, цахим хуудас, уулзалт ярилцлага, хэвлэмэл материал зэрэг сувгаар олон нийтэд хүргэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### 4. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ӨМНӨ ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ:



Ашигт малтмалын хайгуул, судалгаа, олборлолт, хаалт, нөхөн сэргээлт хийх зэрэг уул уурхайн амьдралын мөчлөгийн бүх үе шатанд хүрээлэн буй орчныг хамгаалах, иргэдийн эрүүл мэнд, амьдралын нөхцөлийг хангах, уурхайн ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах арга хэмжээг хэлнэ.



### 5. ИРЭЭДҮЙН ХӨГЖИЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ:

Уул уурхайн компани нь орон нутгийн хөгжилд түлхэц болох үйлдвэрлэл, үйл ажиллагааг дэмжих, иргэдийн боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, дэд бүтцийн хөгжлийг дэмжих чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, тухайн орон нутгийн бие даан, тогтвортой хөгжих боломжийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна.



### 6. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН БАЙХ:

Сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэн ашиглаж, удирдлага зохион байгуулалтыг холбогдох стандартын дагуу менежментийн өндөр түвшинд хэрэгжүүлдэг байхыг хэлнэ.



### 7. ХҮМҮҮНЛЭГ ЁС ЗҮЙТЭЙ БАЙХ:

Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, тэдний амьдралын хэв маяг, уламжлал, үнэт зүйлсийг хүндэтгэдэг байхыг хэлнэ.



### 8. ҮР ӨГӨӨЖТЭЙ БАЙХ:

Уул уурхайн компанийн оруулсан хөрөнгө оруулалт нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд бодит үр өгөөж бий болгосон байхыг хэлнэ.

## ШААРДЛАГА

### 6.1 КОМПАНИЙН САЙН ЗАСАГЛАЛ БА ИЛ ТОД БАЙДАЛ

#### 6.1.1 Санал гомдол авах, түүнийг шийдвэрлэж, эргэн мэдээлдэг үйл явцтай байна.

Санал гомдлын менежмент нь байгууллагын хамт олны санал, хамтрагчдын зөвлөмж, хэрэглэгчийн гомдол саналд үндэслэн цаг алдалгүй сайжруулалт, өөрчлөлт хийх үйл явц юм.

**Санал гомдлын менежментийн үйл явц нь дараах үе шатуудаас бүрдэнэ:**

- Санал гомдлыг хүлээн авах;
- Бүртгэх;
- Шийдвэрлэх;
- Санал гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэн мэдээлэх.

#### 6.1.2 Хууль тогтоомжийн шаардлага ба бусад шаардлагыг тодорхойлж нийцлийн үнэлгээ хийсэн байна.

**Хууль тогтоомжийн шаардлагад дараах зүйлс хамаарна:**

- Хууль тогтоомж (үндэсний, бүс нутгийн эсвэл олон улсын), үүнд хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенц, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актууд;
- Зарлиг, захирамж;
- Захиргааны байгууллагаас гаргасан тушаал;
- Зөвшөөрөл, лиценз болон эрх олгосон бусад хэлбэр;



- Шүүхийн шийдвэр;
- Хэлэлцээр, протокол;
- Хамтын гэрээ хэлэлцээр.

#### **Бусад шаардлагуудад дараах зүйлс хамаарна:**

- Байгууллагын дотоод шаардлага;
- Гэрээний нөхцөл;
- Хөдөлмөрийн гэрээ;
- Сонирхогч талуудтай байгуулсан гэрээ;
- Зохицуулалтын бус стандарт;
- Зөвшилцлийн стандарт, заавар;
- Сайн дурын зарчим, кодекс;
- Техникийн үзүүлэлт, дүрэм;
- Байгууллага болон түүний дээд байгууллагын үүрэг амлалт.

#### **Байгууллага нь:**

- a) Нийцлийн үүргийг үнэлэх давтамж, аргачлалыг тодорхойлно;
- b) Нийцлийн үүргийг үнэлнэ;
- c) Шаардлагатай тохиолдолд нийцлийн үүргийг биелүүлэх арга

хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх;

d) Хууль тогтоомжийн шаардлага болон бусад шаардлагад нийцсэн байдлын талаарх мэдлэг, ойлголтыг бий болгож хадгална;

e) Нийцлийн үүргийн үр дүнг нотлох мэдээллийг баримтжуулж хадгална.

#### **6.1.3 Хариуцлагатай худалдан авалтын бодлого боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх зорилтуудыг тогтооно.**

#### **Байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

- Ханган нийлүүлэгчийг үнэлэх шалгуур тогтооно;
- Хүрээлэн буй орчин, ХАБЭМ болон ёс зүйн шаардлагыг гэрээнд тусгана;
- Нийлүүлэгчийн гүйцэтгэлийг тогтмол үнэлж сайжруулна;
- Орон нутгийн худалдан авалтын хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.



## **6.2 ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА БА ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ**

### **6.2.1 Ажилтны эрхийг хүндэтгэсэн, жендэрийн эрх тэгш байдал болон бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх бодлоготой байна.**

- Байгууллагын үнэт зүйл, соёл, бодлого, үйл ажиллагаанд тэгш байдал, олон ургальч үзэл, оролцоог төлөвшүүлэх;
- Байгууллага нь хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх. Үүнд яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон

бусад нөхцөл байдлаар алагчлахгүй байх;

- Цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох;
- Ажилтнууд хүйсээс үл хамааран ажил, гэр бүлийн үүрэг хариуцлагаа тэнцвэртэй хослуулах нөхцөлийг бүрдүүлэх;

Ажлын байранд бэлгийн дарамтаас ангид орчныг бүрдүүлэх болон урьдчилан сэргийлэх чиглэлээр бүх ажилтнуудын эрх тэгш байдлыг хангах үйл явцыг хэрэгжүүлнэ.

## 6.3 ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРҮҮЛ МЭНД

### 6.3.1 Аюул илрүүлэх үйл явцыг бий болгосон байна.

Байгууллага нь учирч болзошгүй болон аль хэдийн үүссэн (бодитоор илэрсэн) аюулыг илрүүлэх зорилгоор холбогдох үйл явцыг бий болгож, нэвтрүүлэн, тогтмол хэрэгжүүлнэ. Эдгээр үйл явц нь дараах асуудлуудыг харгалзан үзэх боловч үүгээр хязгаарлагдахгүй.

#### Үүнд:

- Ажлын зохион байгуулалт, нийгмийн хүчин зүйлс (үүнд ажлын ачаалал, ажлын цаг, дээрэлхэх, дарамтлах, доромжлох үйлдэл) манлайлал болон байгууллагын соёл;
- Хэвийн болон хэвийн бус үйл ажиллагаа, нөхцөл байдал, дэд бүтэц, тоног төхөөрөмж, материал, бодис, ажлын байрны физик орчин;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний бүх үе ш а т ( д и з а й н , с у д а л г а а , боловсруулалт, туршилт, үйлдвэрлэл, барилга угсралт, үйлчилгээ хүргэлт, засвар үйлчилгээ, устгал);
- Хүний хүчин зүйлс;
- Байгууллагын дотоод болон гадаад орчинд өмнө гарсан аюултай тохиолдлууд, үүнд онцгой байдал, түүний шалтгаанууд орно;
- Болзошгүй онцгой байдлын нөхцөл;
- Хүмүүс, үүнд дараах зүйлсийг анхаарч үзнэ:
  - Ажлын байранд нэвтрэх бүх этгээд (ажилтан, гэрээт ажилтан, зочид, бусад хүмүүс) болон тэдгээрийн үйл ажиллагаа;
  - Байгууллагын үйл ажиллагаанд өртөж болзошгүй ажлын байрны ойролцоох хүмүүс;
  - Байгууллагын шууд хяналтаас гадуур байрлалд ажиллаж буй ажилтнууд;
- Бусад асуудлууд, үүнд дараах зүйлсийг анхаарч үзнэ:
  - Ажлын байр, үйл явц, суурилуулалт, машин, тоног төхөөрөмж, ажлын журам (ажилтны ур чадвар, хэрэгцээнд нийцүүлсэн байдал);
  - Байгууллагын хяналтад байгаа, ажлын байрны ойролцоо үүсэх, ажил гүйцэтгэхтэй холбоотой нөхцөл байдал;
  - Байгууллагын хяналтад байхгүй боловч ажлын байрны ойролцоо үүсэх, хүн гэмтэх, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдал;
  - Аюулын талаарх мэдээлэл, мэдлэгт гарсан өөрчлөлтүүд;
  - Аюул нь физик, хими, биологийн, сэтгэл зүй-нийгмийн, механик, цахилгааны эсвэл хөдөлгөөн ба эрчимд суурилсан байж болно.

### 6.3.2 Аюултай холбоотой эрсдэлийг тодорхойлж, эрэмбэлсэн байна.

Байгууллага нь аюултай холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх үйл явцыг бий болгож, нэвтрүүлэн, тогтмол хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. **Үүнд:**

- Хууль тогтоомжийн нийцэлд үнэлгээ хийх;
- Аюул олж тогтоох болон холбогдох ХАБЭМ-ийн эрсдэлийг үнэлэх;
- Эрсдэлийн үнэлгээний аргачлал, шалгуурын талаарх баримтжуулсан мэдээллийг мөрдөж, хөтөлж хадгална;
- ХАБЭМ-ийн эрсдэлийг үнэлэхдээ байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан аюулын шинж чанарт нийцсэн арга, түвшнийг ашиглах;



ХАБЭМ-ийн эрсдэлүүдийг үнэлэхдээ өдөр тутмын үйл ажиллагаа болон шийдвэр гаргалт (жишээлбэл, ажлын оргил үе, бүтцийн өөрчлөлт) болон гадаад хүчин зүйлс (жишээ нь, эдийн засгийн өөрчлөлт)-ийг харгалзан үзэх;

- Эрсдэлийн үнэлгээний явцад ажилтнуудтай тухай бүр зөвлөлдөх (жишээ нь, ажлын ачааллын өөрчлөлттэй холбоотой);
- Хууль тогтоомжийн шаардлагад тогтмол мониторинг хийж, холбогдох өөрчлөлтийг мэдээлэх (жишээлбэл, хууль тогтоомжийн шинэчлэлт, хамтын гэрээний өөрчлөлт);
- Илэрсэн эрсдэл, өөрчлөлтийн хэрэгцээг хангах зорилгоор шаардлагатай нөөцөөр хангах (жишээ нь, сургалт, шинэ тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл);
- Байгууллага нь ХАБЭМ-ийн боломжуудыг үнэлэх үйл явцыг бий болгож, нэвтрүүлэн хэрэгжүүлэх бөгөөд үүнд:
- Байгууллага, бодлого, үйл явц, үйл ажиллагаанд төлөвлөгдөж буй өөрчлөлттэй уялдуулан ХАБЭМ-ийн гүйцэтгэлийг сайжруулах боломжуудыг тодорхойлох;
- Ажил, ажлын зохион байгуулалт, ажлын орчныг ажилтнуудад илүү тохируулах боломжуудыг үнэлэх;
- Аюулыг устгах болон ХАБЭМ-ийн эрсдэлийг бууруулах боломжуудыг тодорхойлох;
- Үнэлгээний үйл явц нь ХАБЭМ-ийн боломжуудыг тодорхойлсон байх бөгөөд тэдгээрийн үр өгөөж, хэрэгжих боломж, байгууллагын гүйцэтгэлийг сайжруулахад үзүүлэх нөлөөллийг харгалзан үзсэн байна.

### 6.3.3 ХАБЭМ-ийн эрсдэл ба боломжуудад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Байгууллага ХАБЭМ-ийн эрсдэл болон боломжийг удирдах зорилгоор дараах арга хэмжээг төлөвлөнө. **Үүнд:**

- Эрсдэл болон боломжуудыг харгалзан үзэх;
- Холбогдох хууль тогтоомжийн шаардлага болон бусад шаардлагыг харгалзан үзэх;
- Онцгой байдлын үед бэлтгэх, хариу арга хэмжээ авах асуудлыг харгалзан үзэх.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараах байдлаар ажиллана. **Үүнд:**

- Төлөвлөсөн арга хэмжээнүүдийг байгууллагын бизнесийн үндсэн үйл явцуудтай уялдуулан нэгтгэж, нэвтрүүлэх;
- Эдгээр арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үр нөлөөлөлд тогтмол үнэлгээ хийх.

Төлөвлөлтийн явцад байгууллага нь сайн туршлага, боломжит технологийн шийдлүүд, санхүүгийн, үйл ажиллагааны болон бизнесийн шаардлагуудыг харгалзан үзнэ.

Мөн төлөвлөсөн арга хэмжээг хүрээлэн буй орчин, чанар, бизнесийн тогтвортой байдал, эрсдэлийн удирдлага, санхүү, хүний нөөц зэрэг байгууллагын бусад удирдлагын тогтолцоо, үйл явцуудтай уялдуулан нэгтгэхийг зорих нь зүйтэй.



## 6.4 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

### 6.4.1 Хүрээлэн буй орчны талбарыг тодорхойлж, түүнд үзүүлэх нөлөөлөл эрсдэлийг эрэмбэлсэн байна.

Байгууллага нь хүрээлэн буй орчны талбар, тэдгээрээс үүдэлтэй нөлөөлөл, түүнтэй холбоотой аюул, боломжууд болон нийцлийн үүргээс хамаарах эрсдэлүүдийг тодорхойлно.

Хүрээлэн буй орчны талбарыг нарийвчлан тодорхойлсноор байгууллага нь хүрээлэн буй орчны менежментийн гүйцэтгэлээ сайжруулах нөхцөл бүрдэнэ.


Өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүрээлэн буй орчны нөлөөллийг хянахын зэрэгцээ байгалийн давагдашгүй хүчин зүйлс (үер, шороон шуурга, гал түймэр зэрэг)-ийг урьдчилан тооцоолж, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй.

"Хүрээлэн буй орчин" нь өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд "талбар" болон "нөлөөлөл" гэсэн ойлголтуудын ялгаа, харилцан хамаарлыг зөв ойлгох нь чухал. Хүрээлэн буй орчны өөрчлөлтийг тодорхойлсон тохиолдолд үүнийг "нөлөөлөл" гэж үзэх бөгөөд хэрэв тухайн өөрчлөлтийг тодорхойлоогүй бол "талбар" гэж ойлгоно.

#### Дээрх харилцан хамаарлыг тогтооход туслах арга:

ТАЛБАР бол ШАЛТГААН Нөлөөлөл бол түүний ҮР ДАГАВАР

### ДАРААХ АСУУЛТУУДАД ХАРИУЛНА УУ?




#### ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

 АСУУДАЛ?

 НӨЛӨӨЛӨЛ?


#### ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨЛТ

 АСУУДАЛ?

 НӨЛӨӨЛӨЛ?


#### НҮҮРС ХҮЧЛИЙН ХИЙ

 АСУУДАЛ?

 НӨЛӨӨЛӨЛ?

CO<sub>2</sub> нь өөрөө хүрээлэн буй орчны өөрчлөлтийг шууд илэрхийлээгүй тохиолдолд "талбар" гэж үзэх бөгөөд харин CO<sub>2</sub> ялгарлаас үүдэн бий болох үр дагаврыг тодорхойлсон нөхцөлд, тухайлбал уур амьсгалын өөрчлөлт нь "нөлөөлөл" болно.

Иймээс CO<sub>2</sub> ялгаруулалт нь тээврийн хэрэгсэл зэрэг үйл ажиллагаатай холбоотой хүрээлэн буй орчны талбар бөгөөд үүнээс үүдэлтэй өөрчлөлт нь тухайн талбарын нөлөөлөлд хамаарна.



## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ТАЛБАР БА НӨЛӨӨЛЛИЙН ЖИШЭЭ

 ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮТЭЭГДЭХҮҮН ЭСВЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ	 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ТАЛБАР	 НӨЛӨӨЛӨЛ
Аюултай хог хаягдалтай харьцах	Асгарах боломж	Хөрс ба ус бохирдох
	Дэгдэмхий органик нэгдлүүд агаарт хаягдах	Агаарын бохирдол
Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ	Дутуу шаталт	Агаарын бохирдол
	Шингэн түлшний хэрэглээ нэмэгдэх	Байгалийн нөөц хомсдох
Бүтээгдэхүүнийг будах	Агаарын шүүлтүүр хэрэглэх	Аюултай хог хаягдлын үйлдвэрлэл
	Химийн нэгдлүүд агаарт хаягдах	Агаарын хаягдал

### 6.4.2 Эрсдэл ба боломжид чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Байгууллага дараах асуудлуудыг төлөвлөнө:

- Аюул, боломж, хүрээлэн буй орчны талбар болон нийцлийн үүрэгтэй холбоотой эрсдэлүүдийг харгалзан

үзэж, зохих арга хэмжээг авах эдгээр арга хэмжээг байгууллагын бизнесийн үйл явцуудтай уялдуулан нэгтгэж, хэрэгжүүлэх;

- Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үр нөлөөнд үнэлгээ хийх.

## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ТАЛБАРЫГ АНГИЛАХ ЖИШЭЭ

 <b>ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	 <b>ҮЙЛЧИЛГЭЭ</b>	 <b>БҮТЭЭГДЭХҮҮН</b>
<b>“Үндсэн бизнес”-тэй шууд холбоотой</b>	<b>“Үндсэн бизнес”-тэй шууд бус холбоотой</b>	<b>Эцсийн бүтээгдэхүүний хэрэглээ ба савлахтай холбоотой асуудлууд</b>
<b>Эрчим хүч</b>	<b>Туслах материал</b>	<b>Эрчим хүчний эх үүсвэр</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Байгалийн хий</li> <li>• Цахилгаан</li> <li>• Шингэн түлш</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Угаалгын бодис</li> <li>• Аэрозол шүршигч</li> <li>• Ус</li> <li>• Цаас</li> <li>• Бөс даавуу</li> <li>• Химийн шүршигч</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зай</li> <li>• Цахилгаан</li> <li>• Шингэн түлш</li> <li>• Нарны эрчим хүч</li> </ul>
<b>Материал</b> <ul style="list-style-type: none"> <li>• Түүхий эд</li> <li>• Хагас боловсруулсан бүтээгдэхүүн</li> <li>• Дахин боловсруулсан бүтээгдэхүүн</li> <li>• Цацраг идэвхт бодис</li> <li>• Үйлдвэрлэлийн хаягдал</li> <li>• Хаягдлын сан</li> </ul>	<b>Газар арчилалт</b> <ul style="list-style-type: none"> <li>• Бордоо</li> <li>• Гербицид</li> <li>• Пестицид</li> <li>• Ургамал мод тайрах</li> <li>• Цахилгаан тоног төхөөрөмж</li> </ul>	<b>Сав боодол</b> <ul style="list-style-type: none"> <li>• Цаас</li> <li>• Картон</li> <li>• Хуванцар</li> <li>• Хөнгөн цагаан</li> <li>• Ган</li> <li>• Мод</li> <li>• Бусад материал</li> </ul>
<b>Байгалийн нөөц</b>	<b>Засвар үйлчилгээ</b>	<b>Тээвэрлэлт, хүргэлт</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Ус</li> <li>• Газар ашиглалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Уусгагч</li> <li>• Тос</li> <li>• Тосолгооны бодис</li> <li>• Ашигласан материал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шатахуун</li> <li>• Тос</li> <li>• Шингэн материал</li> <li>• Яндангийн утаа</li> </ul>
<b>Химийн бодис</b>	<b>Тээвэрлэлт, хүргэлт</b>	<b>Мэдээлэл харилцаа</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Аюултай бодис</li> <li>• Аюултай хаягдал</li> <li>• Уусгагч</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шатахуун</li> <li>• Тос</li> <li>• Шингэн материал</li> <li>• Яндангийн утаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цаас</li> <li>• Хор</li> </ul>
<b>Сав боодол</b>	<b>Хүнс/Катеринг</b>	<b>Хэрэглээ ба хаягдал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Цаас</li> <li>• Картон</li> <li>• Хуванцар</li> <li>• Хөнгөн цагаан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цаасан/хуванцар эдлэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дахин боловсруулах материал</li> <li>• Цахилгааны хэрэглээ</li> </ul>



## 6.5 НУТГИЙН ИРГЭД БА ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА

### 6.5.1 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилд ороход нь давуу нөхцөл бүрдүүлнэ.

Байгууллага хүний нөөцийн төлөвлөлтөд дараах асуудлуудыг анхаарч үзнэ.

- Хөдөлмөр эрхлэх боломж нь тухайн орон нутгийн иргэдийн ур чадвартай нийцэх, эс нийцэхийг тодорхойлох
- Орон нутагт ажлын байр бий болгох, шинээр Аж ахуйн нэгж байгуулагдах боломжийг дэмжихийг зорих;
- Тухайн орон нутгийн чадварлаг ажиллах хүчнийг дэмжих, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

### 6.5.2 Орон нутгийн харилцаа хариуцсан ажилтантай байна.


Байгууллага нь орон нутгийн харилцаа

хариуцсан ажилтныг томилж, түүний үүрэг, хариуцлага, эрх мэдлийг тодорхойлсон байна. Уг үүргийг бусад албан тушаалтай хавсран гүйцэтгэж болно. Томилогдсон ажилтны мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор дараах чиглэлээр сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

a. Байгууллагаас орон нутгийн иргэд болон нөлөөлөлд өртөж болзошгүй талуудтай зөвлөлдөх үйл явцын шаардлага, аргачлал;

b. Сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэдийн түүх, уламжлал, эрхийн талаарх мэдлэг;

c. Соёлын ялгаатай байдлыг ойлгож, мэдрэмжтэй, хүндэтгэлтэй харилцах ур чадвар.









Энэхүү гарын авлагыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Эрдэс баялгийн менежментэд шударга байдлыг бэхжүүлэх-Интегра Санаачилга” төслийн санхүүжилтээр Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн хэрэгжүүлж буй “Жижиг дунд компаниудад зориулсан Хариуцлагатай уул уурхайн кодекс” тэтгэлэгт төслийн хүрээнд боловсруулав.

Гарын авлагад тусгагдсан агуулга, дүгнэлтүүд гүйцэтгэгч байгууллагын байр суурийг илэрхийлж байгаа бөгөөд төслийг санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн байр суурийг илэрхийлээгүй болно.

 [www.miningmongolia.mn](http://www.miningmongolia.mn)  
 [Info@miningmongolia.mn](mailto:Info@miningmongolia.mn)  
 +976 7011 0163



 Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци  
 Mongolian National Mining Association  
 @miningmongolia  
 @mongolian\_mining\_association